

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДОТООД АУДИТЫН 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 07

Улаанбаатар хот

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын журам”, Гадаадын иргэн, харьяатын газрын Дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөнд үндэслэн дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг.Төсөв, санхүүгийн чиглэлээр:

Байгууллагын дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөний дагуу төсөв, санхүү болон үйл ажиллагааны чиглэлээр 4, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 4, төлөвлөгөөт 8, нийцлийн чиглэлээр төлөвлөгөөт бус 1, нийт 9 удаагийн хяналт шалгалтыг хийж, гүйцэтгэлээ.

Хяналт шалгалтыг төрлөөр нь ангилвал:

№	Хяналт, шалгалтын төрөл	Хамрагдсан байгууллагын нэр	Хяналт шалгалтын тоо	Тайлбар
1	Санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр аудит	Хойд бүс дэх газар	1 удаа	Төлөвлөгөөт
2		Дорноговь аймаг дахь газар	1 удаа	Төлөвлөгөөт
3		Баруун бүс дэх газар	1 удаа	Төлөвлөгөөт
4		Зүүн бүс дэх газар	1 удаа	Төлөвлөгөөт
5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд	Төв болон орон нутаг дахь газар, хэлтэс	4 удаа	Төлөвлөгөөт
6	Нийцлийн аудитын чиглэлээр	Захиргаа, удирдлагын газрын архивын нэгж	1 удаа	Төлөвлөгөөт бус

а) Байгууллагын даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01-02/13 дугаартай удирдамжийн дагуу Хойд бүс дэх газрын 2022 он, 2023 оны 1 дүгээр улирлын төсөв, санхүүгийн тайланд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, дүнг удирдлагад 04 дүгээр сарын 10-ны өдөр 01-02/49 дугаарын илтгэх хуудсаар танилцуулж, тус бүсийн газарт “Ажлын хариуцлагыг сайжруулах тухай” 03 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг тооцож ажиллалаа.

б) Байгууллагын даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01-02/26 дугаартай удирдамжийн дагуу Дорноговь аймаг дахь газрын 2022 он, 2023 оны 1 дүгээр улирлын төсөв, санхүүгийн тайланд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, дүнг удирдлагад 01/77 дугаарын илтгэх хуудсаар танилцуулж, тус газарт 07 дугаар сарын 05-ны өдөр 01/1143 дугаартай албан бичгээр

аудитын 6 зөвлөмж өгч, тус бүсийн газар зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.

в) Байгууллагын даргын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 01-02/27 дугаартай удирдамжийн дагуу Баруун бүс дэх газрын 2022 он, 2023 оны 1 дүгээр улирлын төсөв, санхүүгийн тайланд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, дүнг удирдлагад 01/77 дугаарын илтгэх хуудсаар танилцуулж, тус газарт 07 дугаар сарын 05-ны өдрийн 01/1144 дугаартай албан бичгээр аудитын зөвлөмж өгч, гүйцэтгэлд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 08 дугаар сарын 25-ны 01-09/08 дугаарын илтгэх хуудсаар удирдлагад танилцуулан, аудитын 7 зөвлөмж өгч, биелэлт 88.8 хувьтай байна.

г) Байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 01-02/58 дугаарын удирдамжийн дагуу Зүүн бүс дэх газрын 2022 он, 2023 оны 1-3 улирлын төсөв, санхүүгийн тайланд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, дүнг удирдлагад 11 дүгээр сарын 27-ны өдөр 01-02/169 дугаарын илтгэх хуудсаар танилцуулж, тус газарт 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/2118 дугаартай албан бичгээр аудитын 3 зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

д) Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төв болон орон нутаг дахь нэгжүүдийн цахим хуудсан дахь хуулийн хэрэгжилт болон түүнийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх талаар байгууллагын даргын 2023 оны 01-09/01, 01-09/02, 01-09/03, 01-09/05 дугаартай удирдамжийн дагуу 2022 оны 4, 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудитын хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, байгууллагын даргад 4 удаагийн 01-09/01, 01-09/05, 01-09/06, 01-09/14 дугаартай илтгэх хуудсаар танилцуулан, үр дүнг Санхүүгийн хэлтэс болон боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 2023 оны 09/06, 01-09/06, 01-09/14 дугаартай 3 удаагийн дотоод албан бичгээр зөвлөмж өгч, биелэлтийг тооцож ажиллалаа.

Дотоод аудитын 2023 оны хагас жилийн ажлын тайлан, Үндэсний аудитын газрын зөвлөмжийн хагас жилийн хэрэгжилтийг 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 02/1232 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Хоёр.Нийцлийн аудитын чиглэлээр:

Байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн байгууллагын даргаар 12 дугаар сарын 28-ны өдөр 4 чиглэлээр 11 арга хэмжээ бүхий “2023 онд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулж, тус төлөвлөгөөг 04 дүгээр сарын 14-ний өдрийн 02/595 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж ажиллалаа.

Байгууллагын 2022 оны эрсдэлийн тайланг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2087 дугаар албан бичгээр, 2023 оны 1 дүгээр улирлын эрсдэлийн тайланг 05 дугаар сарын 05-ны өдөр tsevelmaa@mojha.gov.mn цахим хаягаар, 2023 оны эрсдэлийн тайланг 11 дүгээр сарын 28-ны өдрийн 09/2054 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ

систем (mojha.unelgee.gov.mn)-д 2022 оны 12 дугаар сарын 02, 2023 оны 05 дугаар сарын 03, 11 дүгээр сарын 28-ны өдрүүдэд эрсдэлийн бүртгэлд арга хэмжээний биелэлтийг оруулж, үнэлэн, тайланг баталгаажууллаа.

Байгууллагын даргын 2023 оны 01-09/04 дугаарын удирдамжийн дагуу Захиргаа, удирдлагын газрын архивын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд нийцлийн аудитын хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, үр дүнг байгууллагын даргад 08 дугаар сарын 08-ны өдөр 01-09/07 дугаар илтгэх хуудсаар танилцуулж, мөн сарын 16-ны өдөр 09/16 дугаарын дотоод албан бичгээр Захиргаа, удирдлагын газарт архивын талаар авч хэрэгжүүлэх зөвлөмж өгч, 10 дугаар сарын 04-ний өдрийн 02/83 дугаартай дотоод албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг тооцож ажиллалаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/1224 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй Хууль зүй, дотоод хэргийн сайдын 5, байгууллагын даргын баталсан 4 шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/688 дугаар албан бичгээр хариуг хүргүүлэв.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 10/962 дугаар албан бичгийн дагуу хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг гарган, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын дагуу үнэлгээ хийн, 05 дугаар сарын 20-ны өдөр info@shilen.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.

Байгууллагын даргын 2022 онд батлан гаргасан 246 тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг удирдлагад 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр танилцуулж, тайланг зөвлөмжийн хамт Захиргаа, удирдлагын газарт хүргүүллээ.

Байгууллагын даргын батлан гаргасан 7 албан даалгаварт хяналт-шинжилгээ хийн, тайланг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр удирдлагад танилцуулж, 06 дугаар сарын 12-ны өдрийн 09/11 дугаартай дотоод албан бичгээр Захиргаа, удирдлагын газарт зөвлөмж өгч ажиллалаа.

Байгууллагын даргын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/303 дугаар тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн тайланд ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан, нөхцлийг салбарын хэмжээнд судалж танилцуулга бэлтгэх чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийг байгуулж, 09 дүгээр сарын 26, 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдсан хуралд нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн оролцлоо.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын албан хаагчийг чадавхжуулах, харилцан туршлага солилцох дотоод аудитын хөтөлбөрийн дагуу Шүүх шинжилгээний ерөнхий газрын

мэргэшлийн эрх олгох сургалтын үйл ажиллагаанд 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрүүдэд нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн дотоод аудитын хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.

Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн 2022 оны жилийн эцсийн тооллогын А/222 дугаар тушаал, 2023 оны хагас жилийн тооллогын А/186 дугаар “Эд хөрөнгийн тооллого зохион байгуулах тухай” тушаалын дагуу ажлын хэсэгт аудит хариуцсан мэргэжилтэн, 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралд хэлтсийн дарга, аудит хариуцсан ахлах мэргэжилтэн нар оролцож, төв болон орон нутаг дахь нэгжүүдийн 2023 онд элэгдлийн хугацаа дууссан хөрөнгийг актлах болон дахин үнэлэх, балансаас балансад шилжүүлэх талаар хэлэлцэн холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТЭС